



ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ
СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД

НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7,
1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160 0035
Утас: (976-11) 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2024.09.19 № 03/5373
танай -ны № -т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус байгууллагаас зарласан НЗДТГ/20240101019 дугаартай “Сэлбэ дэд төвийг түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслийн эхний ээлжийн барилга угсралтын ажил, 13 га” төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгуудад дараах хариуг хүргүүлж байна.


Тодруулга	Хариулт
<p>Тендерийн баримт бичгийн 2 дугаар бүлгийн ТШЗ 19.2-ын 4 дүгээр заалтад Ажил гүйцэтгэж дуусах хугацаа 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдөр байхаар заасан байна. Энэ жилийн барилга угсралтын улирал үндсэндээ дуусгавар болж байгаа бөгөөд ирэх жилийн газар шорооны ажил 4 дүгээр сараас эхэлнэ гэж тооцвол найман сарын хугацаанд бүх ажлыг гүйцэтгэхэд хүндрэлтэй байна. Иймээс энэ асуудлын талаар тодруулга өгөхийг хүсэж байна.</p>	<p>Захиалагчаас баталсан тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн санхүүгийн болон техникийн чадавх, туршлага, бусад шаардлагыг хангах аж ахуй эрхлэгч нь тус төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажлыг 2024, 2025 оны төсвийн жилд гүйцэтгэхээр ажил гүйцэтгэх нарийвчилсан хугацааны график, календарчилсан төлөвлөгөөг баталгаажуулан ирүүлнэ.</p>
<p>Тендерт гадаадын хоёр компани оролцохдоо хоёулаа цахим системд бүртгүүлж урилга авах уу, эсвэл нэг нь бүртгүүлээд нөгөөх нь хамт орох уу.</p>	<p>Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/249 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Бүртгэл хөтлөх, мэдээллийг баталгаажуулах журам”-д заасны дагуу аж ахуй эрхлэгчийг мэргэжлийн байгууллага цахим системд бүртгэснээр аж ахуй эрхлэгч цахим системд хандаж, худалдан авах ажиллагаанд оролцоно. Аж ахуй эрхлэгч цахим системд бүртгүүлэхээс өмнө Цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.1-д заасан гэрчилгээжүүлэх байгууллагаас тоон гарын үсэг авсан байна.</p> <p>Тендерийн баримт бичгийн I бүлгийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэгт заасны дагуу түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгчээр оролцогч нь гадаадын этгээд бол цахим системд бүртгүүлж, гэрээг баталгаажуулах шаардлагагүй.</p>

1110204233

ТШЗ 19.1-ийн 2.Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэлд заасан Цамхагт краны хүчин чадал 10 тн болон түүнээс дээш гэсэн үзүүлэлтийг тодотгож өгнө үү.	Төсөлд хэрэглэгдэх үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэлд Цамхагт кран 2 ширхэг, хүчин чадал нь 10 тонн болон түүнээс дээш гэж шаардсан бөгөөд хүчин чадлын үзүүлэлтийг угтаа өргөх хүчин чадал нь 10 тонноос багагүй гэж ойлгоно.
---	--

Зураг төсөв, ажлын тоо хэмжээнд өөрчлөлт ороогүй тул тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгахгүй болохыг мэдэгдье.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



П.ХАДБААТАР